



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

᠑᠐᠑1 оны 0᠑ сарын 01 өдөр

Дугаар А/3᠑8

Мандалговь

Эзэмшил газрын хэмжээг өөрчилж,  
нэгж талбарыг нэгтгэх тухай

Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дахь заалт, 31 дугаар зүйлийн 31.2 дахь заалт, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалт, эзэмшил газраа нэгтгэн, хэмжээг өөрчилж гэрчилгээ авах иргэний хүсэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт (Бага тойруу-5-511 тоот) байршилтай иргэн Баярсайхан овогтой Бямбасүрэн (ЗМ:93040307)-ийн амины орон сууцны зориулалттай 288м.кв (0.02га) эзэмшил газар, мөн (Бага тойруу-5-509 тоот) байршилтай иргэн Баярсайхан овогтой Бямбасүрэн (ЗМ:93040307)-ийн орон сууцны зориулалттай 288 м<sup>2</sup> /0.02га/ газрыг нэгтгэж одоо байгаа 606 м.кв (0.06га) болгон хэмжээг өөрчилж, үйлчилгээтэй нийтийн орон сууцны зориулалтаар нь 22 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (С.Бат-Оргил), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулж аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/136 тоот захирамж, 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/230 тоот захирамжийн Б.Бямбасүрэнд холбогдох хэсэг, мөн газар эзэмших 000131281, 000162011 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210837